**БАЯНХОНГОР АЙМАГ**
**БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 04 өдөр Дугаар А/66 Хөхбүрд

Хорио цээрийн дэглэмийг цуцалж,
хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.4 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Мэргэн 4 дүгээр багийн нутаг Ар гуугын худаг нэртэй газар үхэрт халдварт "Боом" өвчний халдварыг таслан зогсоох голомтыг устгах халдвар дамжих, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон "Хорио цээрийн дэглэм"-ийг цуцалж 2025 оны 06 дугаар сарын 04-нөөс 06 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл 7 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Ёндонпил (Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч)

Гишүүд: Ж.Жамъяндагва (Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)
Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)
Д.Авид (Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга)
Т.Төрбат (Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга)
М.Сэр-Од (Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)
Ё.Дамдинпүрэв (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)
Т.Энх-Амгалан (Амгалан ариун сүрэг ХХК-ны малын их эмч)
Б.Лхагвасүрэн (Хишиг Тайжын овоо-ХХК-ны малын эмч)
Л.Сэргэлэн (Асгамба малын эмч)
Б.Энхмөнх (Жолооч)
Сумын мэргэжлийн анги бүрэлдэхүүн

3.Хил залгаа багууд нутаг дэвсгэрт ойр орчим зусаж буй малчдын малд үзлэг, ариутгал халдваргүйтгэл хийх, сэжигтэй шинж тэмдэг илэрвэл сумын Онцгой байдлын штабт цаг тухайд нь мэдээлж ажиллахыг "Амгалан ариун сүрэг" ХХК-ны

642501059

малын их эмч (Т.Энх-Амгалан), Хишигт тайжын овоо ХХК-ны малын эмч (Б.Лхагвасүрэн), "Асгамба" малын их эмч (Л.Сэргэлэн) нарт үүрэг болгосугай.

4.Халдварт боом өвчний талаар малчид мал бүхий иргэдийг мэдээ мэдээллээр хангаж, тандалт судалгаа хийж хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Ж.Ёндонпил)-т даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА Т.БЯМБАДОРЖ

642501055

᠔ · ᠬᠠᠷᠢ—ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠲᠠ (ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯ

ᠬᠠᠷᠢᠶᠠᠯ ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ ᠶᠢᠨ—ᠠᠴᠠ ᠬᠢ ᠪᠠ ᠬᠠᠷᠢ ᠪᠦᠬᠦᠨ)

᠖ · ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢᠯᠡᠯᠲᠡ (ᠣᠨᠴᠠ ᠪᠣᠰᠤᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠥᠷᠥᠯ—ᠳᠤᠰ—ᠶᠢᠨ ᠬᠢ ᠪᠠ ᠪᠦᠬᠦᠨ)

᠗ · ᠳᠠᠭᠠᠯᠳᠤᠯ (ᠨᠡᠶᠢᠲᠡ ᠬᠢ ᠪᠠ ᠪᠦᠬᠦᠨ)

᠘ · ᠬᠠᠷᠢᠴᠠᠩᠭᠤᠢ (ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠪᠣᠯᠤᠨ)

ᠲᠣᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠪᠠ ᠬᠠᠷᠢ ᠳᠦᠷᠰᠦᠯᠡᠯ ᠦ᠄ ᠳᠡᠭᠡᠷᠡᠬᠢ ᠳᠦᠷᠮᠦᠳ ᠪᠦᠷ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠳᠡᠬᠦ [illegible]